

“ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 4-р сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

“Фронтинер Лэнд Групп” ХК-ийн Хувь Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг 2019 оны 4 сарын 30-нд Улаанбаатар хотод зарлан хуралдуулав. Хурал Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт орших Сити Плаза 2 дугаар давхрын 2020а тоот өрөөнд 11цаг 10 минутад эхлэв.

Хурлын ирц 80,5%-тай болохыг Хурлын Тооллогын Комиссын Дарга Д.Чулуунбаатар танилцуулав.

Хурлын ирц бүрдсэн тул Хурлын дарга Р.Отгонбат хурлыг нээн, компанийн ХЭЭХ-аар хэлэлцэх асуудлуудыг танилцуулсан ба хуралд оролцогсод асуудлуудаа хэлэлцэж явж байгаад санал асуулгаа авахаар тохиров.

Хурлаар хэлэлцсэн асуудлын жагсаалт:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
4. “Морьт Импекс” ХХК-тай байгуулах гэрээг дүгнэх, шаардлагатай арга хэмжээг авах
5. Бусад

“Фронтинер Лэнд Групп” ХК -ийн Гүйцэтгэх Захирлын үүрэг гүйцэтгэгч Камолиддин Талипов компанийхаа тухай товч танилцуулав. Мөн компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг 2025 оны бизнес төлөвлөгөөтэй хамт танилцуулав. Тэрээр компанийн ерөнхий танилцуулга болон үйл ажиллагааны өнөөгийн байдлыг танилцуулахдаа:

“Фронтинер Лэнд Групп” ХК нь анх “Туул Сонгино Усны Нөөц” ХК нэртэйгээр Техникийн Усны Байгууламж, Ундны Усны Байгууламж, Усан Цэнэгт Цахилгаан Станц гэсэн гурван төслийг хэрэгжүүлэхээр 2006 оны 12-р сарын 30-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Тус компани нь эхний төсөл болох Техникийн Ус Боловсруулах байгууламжийг барих зорилгоор Монголын Хөрөнгийн Биржид хувьцаагаа 2007 оны 12 дугаар сард анх гаргасан бөгөөд нийт 13 200 061 250 төгрөгийн хөрөнгийг босгосон байна. 2010 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр хуралдсан Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлаар дэд бүтцийн эдгээр гурван төслийг эдийн засгийн үр ашиг багатай гэж тооцсоны үндсэн дээр үйл ажиллагаагаа өөрчлөх шийдвэр гарсан. Төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон гол шалтгаан нь Компани төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, патент, засгийн газрын агентлагуудтай байгуулсан гэрээ зэрэг биет бус хөрөнгүүдийг эзэмшдэггүй байсантай холбоотой. Эдгээр тусгай зөвшөөрөл, патент, газрын эрх нь тус компанийг үүсгэн байгуулсан анхны үүсгэн бйагуулагчийн өмчлөлийн компанийн нхэр

дээр байсантай холбоотой. Компани үүнээс хойш хэд хэдэн төслийг хэрэгжүүлэхээр оролдон нийлээд ажил хийсэн боловч гадны хөрөнгө оруулагчдын монголыг сонирхох сонирхол буурсны улмаас хөрөнгө оруулалт татаж чадаагүй ба төлөвлөсөн ажлыг хийж гүйцэтгэх боломжгүй болсон. Компани өнгөрсөн жилийн хугацаанд компанийн гол зардал болсон цалин, татвар, нийгмийн даатгалын зардалыг багасгах үүднээс ажилчдын тоог эрс цөөлсөн. Та бүхэнд өнгөрсөн жилийн санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг тараасан байгаа. Асуух зүйл байвал асуугаарай. Компани ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлах боломжгүй болсныг та бүхэнд бас тайлагнаж байна.

Компанийн санхүүгийн тайлангууд нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байна гэсэн санал дүгнэлт гарсан. Компани нь Монгол улсын татварын хууль тогтоомж, заавар журмын дагуу хугацаанд нь татварын тайлангаа гаргаж өгдөг.

Гүйцэтгэх Захирлын үүрэг гүйцэтгэгч Камолиддин Талипов дараагийн хэлэлцэх асуудал болох Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг танилцуулахдаа Узбек болон шинэ тутам хөгжиж буй зах зээл рүү нэвтрэхээр зорьж байгааг илэрхийлэв. Харьцангуй хязгаарлагдмал Монголын зах зээлд үйл ажиллагаа явуулах нь учир дутагдалтай байгаа тул хаана ямар боломж байгааг соргоогоор олж хараад, Узбекистаны зах зээлд үйл ажиллагаагаа тэлэх сонирхолтой компаниуд Монголд их болсон байгаа тул Узбекистанд бизнес аялал зохион байгуулах, менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэн тэнд үйл ажиллагаагаа тэлэх бүхий л ажилд зөвлөхөөр оролцон ашиг орлогоо нэмэгдүүлэх бүрэн боломж байна. Учир нь би Узбек хүн учираас тэнд надад маш их танил тал, боломж байгааг дурьдах нь зөв байх. Компани 10 тэрбум хүртэл төгрөгийг нэмж хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх талаар хуралдааны үеэр түлхүү мэдээлж ярилцав. Монгол болон хөгжиж буй шинэ тулгар зах зээлтэй улсуудын үл хөдлөх хөрөнгийн салбарт дараах цогц бүтээгдэхүүн, үйлчилгээний багцуудыг санал болгож ажиллахаар төлөвлөж байгааг илэрхийлэв. Үүнд: i) Дахин төлөвлөлтийн орон сууцны болон оффисын барилга, төслийн хөрөнгө оруулалт, бүтээн босголт ii) Менежментийн зөвлөх үйлчилгээнүүд зэрэг багтах юм.

Бусад гэх асуудлын хүрээнд нэмж хувьцаа гаргах, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, тэргүүн ээлжинд хувьцаа худалдан авах эрх эдлүүлэхгүй тухай, хуулийн дагуу шаардах эрх үүсэх тухай, ашигтай салбарт үйл ажиллагаа явуулдаг, хөрөнгө мөнгө ихтэй, цаашид найдвартай олон жилийн хугацаанд ашигтай ажиллах, эрсдэлгүй компанийг нэгтгэх процесс байж болох юм гэсэн саналыг дэвшүүлэн дэмжиж байгаагаа хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд илэрхийлэв. Энэ нь цаг хугацаа хэмнэх, бэлэн бизнесээс өгөөж хүртэх, ингэснээр бид хувьцаа эзэмшигчиддээ ноогдол ашиг хувиарлах цаашлаад манай хувьцааны ханш өсөх боломжтой болно гэж бодож байна. Компанийн хувьцааг хуваах эсвэл нэрлэсэн үнийг буулгах гэсэн хоёр арга зам байгааг тайлбарлав. Мөн компанийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдаж авах болон хувьцааг эргүүлэн компанид худалдах шаардах эрх хэрэгжүүлэх тухай танилцуулав. Нийт 10 тэрбум хүртэл төгрөгийн хөрөнгө босгох бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хороотой энэ талаар ярилцсан. Компанийн хувьцаа анх 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй гаргаж байсан бол одоогоор манай хувьцааны ханш 185 төгрөг орчим байна. Тиймээс нэрлэсэн үнээс доогуур худалдаж болохгүй байна. Компанийн тухай хуулийн 31.2-т хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх арга

замуудыг дурдсан байдаг. Шинээр 1000 төг-өөр хувьцаа гаргахад зах зээл дээр 185 төгрөгөөр худалдаалагдаж байгаа тул худалдан авах хүн олдохгүй. Тиймээс нэрлэсэн үнээ буулгах арга байна.

Хуулийн дагуу нэрлэсэн үнийг нэмж, бууруулж болно. Ингэснээр НББ-ийн хувьд л өөрчлөлт (бичилт) орох юм. “Нэмж төлөгдсөн капитал” дансанд бүртгэгдэнэ хэмээн тайлбарлав.

Компанийн Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал Санхүүгийн Зохицуулах Хорооны шийдвэрээс хамаарах тухай мэдэгдэв. Компанийн үйл ажиллагааны чиглэлд зөвлөх үйлчилгээнээс гадна хуулиар зөвшөөрсөн, тусгай зөвшөөрөл шаардагдахгүй үйл ажиллагааны чиглэлүүдийг нэмж оруулах саналтай байна. Энэ компани ашигтай ажиллах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Үргэлжлүүлэн сүүлийн хэлэлцэх асуудал болох компани, үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан Туул Сонгино Усны Нөөц Цогцолбор төсөлтэй холбоотой Морьт Импекс ХХК-тхй байгуулсан гэрээг дахин хэлэлцэж зохих шийдвэрүүдийг гарган гэрээг дахин шинээр байгуулах, хууль шүүхийн бийгууллагуудад хандан зохих шийдвэрүүдийг хурдан гаргах хэрэгтэй байна.

Төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон гол шалтгаан нь Компани төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, патент, засгийн газрын агентлагуудтай байгуулсан гэрээ зэрэг биет бус хөрөнгүүдийг эзэмшдэггүй байсан юм. Үүсгэн байгуулагчид биет бус хөрөнгөөр компанид хөрөнгө оруулалт хийхгүй байхаар шийдэж, харин тэдгээрийг ашиглан төслүүдээ компаниас хараат бусаар хэрэгжүүлэхээр шийдсэн. Мөн үүсгэн байгуулагчид компанид хөрөнгө оруулалт хийх үүргээсээ чөлөөлөгдөхийг хүссэн. Тиймээс Компани үүсгэн байгуулагчидтай гэрээ байгуулсан ба уг гэрээ ёсоор үүсгэн байгуулагчид үүргээсээ чөлөөлөгдөж энэ дагуу мөн тэдний компанид хувьцаа эзэмших эрх цуцлагдсан. Гэрээ ёсоор эдгээр хөрөнгийг компанийн санхүүгийн тайланд тусгасан бөгөөд, үүсгэн байгуулагчид төсөлдөө хөрөнгө оруулагч олж, компанид 4 588 876 575 төгрөгөө нөхөн төлөхөөс наана хөрөнгийг үүсгэн байгуулагчдад шилжүүлэхгүй байхаар 2018 онд шийдвэрлэж байсан байна.

Мөн компанийн өмнө нь сонгогдсон ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа тул шинээр ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудлыг бусад гэх асуудлын хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй байна. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвших хүсэлт бусад хувьцаа эзэмшигчдээс ирүүлээгүй.

Хараат бус ТУЗ-ийн гишүүн Р.Отгонбат: Компани маш сайн ажиллах хэрэгтэй байна. Компанийн төр төлбөрүүдийг яаралтай барагдуулах, хууль шүүхийн байгууллагад хандан зарим нэгэн авах ёстой өр төлбөрөө авах, хуулийн компанитай хамтран ажиллах хэрэгтэй байх гэж бодож байна. Шинэ ТУЗ бас их сайн ажиллах хэрэгтэй байна.

Ийнхүү хурлаар хэлэлцэх бүх асуудлуудыг хэлэлцэж нэмэлт тодруулга хийсний дараа хурлын дэгийн дагуу Тооллогын комиссын дарга саналын хуудас бөглөх зааварчилгаа, тооллогын журмыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулаад Хурал зохион

байгуулах бүрэлдэхүүн хуралд биеэр ирсэн хувьцаа эзэмшигчдээс холбогдох журмын дагуу саналын хуудсыг хураан авч тоолов.

Саналын хуудсуудыг нягтлан шалгаж, тооллогын нэгтгэсэн дүнг Тооллогын Комиссын дарга Д.Чулуунбаатар хувьцаа эзэмшигчдэд уншиж танилцуулав.

Санал хураалтад халаасны хувьцааг хассан саналын эрх бүхий нийт 9,258,196 хувьцаанаас 7,454,576 ширхэг хувьцаа буюу 80,5 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хурлаар хэлэлцэх асуудлуудаар өгсөн саналын үр дүн бүгд зөвшөөрсөн байгааг мэдэгдэв.

Мөн ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтад хураалтад халаасны хувьцааг хассан саналын эрх бүхий нийт 9,258,196 хувьцаанаас 7,454,576 ширхэг хувьцаа буюу 80,5 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид санал өгч ТУЗ-ийн дараах гишүүдийг шинээр сонгов.

Т. Камолиддин, Д.Батсайхан, Р.Отгонбат, Т.Толен, О.Амартүвшин, Х.Эльёр нарыг ердийн гишүүнээр, У.Саодат, Х.Мухаметгалим, А.Дилдора нар хараат бус гишүүнээр сонгогдов. ТУЗ-ийн зардлын төсвийг өмнөх жилийнхээр батлах нь зөв байх. Гэхдээ өмнөх жил компани ашигтай ажиллаагүй тул ТУЗ-ийн зардал бараг гараагүй.

Хурлын дарга хурлаас гарах тогтоолын төслийг нэг бүрчлэн уншиж танилцуулан, хурал амжилттай болсныг зарлаж хурлыг хаан үг хэлээд, хуралтай холбоотой бүх бичиг баримтыг зохих журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх болохыг мэдэгдэн хурлыг албан ёсоор 13цаг 15 минутад хаав.

ХЯНАГДАН:



Р.ОТГОНБАТ /ХУРЛЫН ДАРГА/

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

А.Амирлан

А.АМИРЛАН

/ТУЗ-ИЙН

НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА/